



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг
нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын
хэрэгжилт, үр дүн”*

*Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ нь
нийгэмд ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг
нэмэгдүүлэх үндсэн үүргээ төдийлөн үр дүнтэй хэрэгжүүлж
чадахгүй байна.*

АУДИТЫН КОД: СБА-2022/20-ШТА-ГА

Баруун-Урт 2022 он Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа
Утас: 70518396, Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер Г.Даваа
Утас: 70512123, Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Ахлах аудитор С.Ариунбаяр
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг
Утас: 70512127, Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Агуулга

Агуулга.....	2
Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товчьег	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээдэл	5
БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө хуваарилаагүй, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангаж боловсруулаагүй, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл дүрэм заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	6
1.1 Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ дунд, богино, урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй, хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцоогүй байна.	6
1.1.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийн зорилго, зорилтууд уялджээ.	6
1.1.2 Бодлогын баримт бичгийн уялдаа хангаагдахгүй байна	6
1.1.3 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаагаар 25 ажил мэргэжилд 1,648 ажиллах хүчний илүүдэл үүсээд байна.....	7
1.1.4 Зарим байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгуулах саналаа тооцоо судалгаагүй, санхүүжих эх үүсвэр тодорхойгүйгээр хүргүүлжээ	9
1.2. Орон нутгийн төсөвт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө батлагдаагүй байна	10
1.2.1. Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө төлөвлөөгүй байна.....	10
1.2.2. Бодлогын баримт бичигт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг тусгажээ	11
1.2.3. Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.	12
1.3. Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаагүй байна	13
1.3.1. Төр захиргааны байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг уялдуулж тусгаагүй байна	13
1.3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн онцлогт тохирсон бодлогогүйгээс ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийг байнгын ажлын байраар хангаж чадахгүй байна.....	14
1.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	15
1.3.4 Бодлогын зарим зорилт арга хэмжээний биелэлтийг, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үндэслэн үнэлээгүй байна	17
БҮЛЭГ2: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулсан боловч төсөл, хөтөлбөр үр дүнтэй хэрэгжээгүй, иргэдэд үзүүлсэн үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн системд давхардуулан бүртгэжээ.....	18
2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг тооцож, тайлагнаагүй байна.....	18
2.1.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамрагдсан иргэдийг мэдээллийн системд давхардуулан бүртгэжээ	18
2.1.2. Аймгийн хэмжээнд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн эзлэх хувь улсын дунджаас өндөр байна.....	21
2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцож тайлагнаагүй байна.....	23

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2.2 Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаагүй, албан ажлын байр нэмэгдээгүй, хөтөлбөрт хамрагдсан иргэд ихэвчлэн албан бус хөдөлмөр эрхэлж байна	24
2.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна.	24
2.2.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй хэрэгжжээ.	29
2.2.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлж, дүгнээгүй байна.	31
2.3 ХЭДС-ин хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулж байгаа боловч ХБИ ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагын төлбөрийг бүрэн төлөөгүй байна.	32
2.3.1 ХЭДС-д зөвхөн улсын төсвөөс санхүүжилт олгосон байна	32
2.3.2 ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулжээ.	33
2.4 МСҮТ-ийн төгсөгчид мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэлт хангалтгүй, хөдөлмөрийн зах зээлд шингээлт багатай мэргэжлээр элсэлт авах эрсдэл үүссэн байна.	34
2.4.1 Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 39.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулжээ.	34
2.4.2 МСҮТ-ийн төгсөгчдийн 30.8 хувь нь мэргэжлийн дагуу ажлын байраар хангагджээ.	35
2.5 Төрөөс цар тахлын үед иргэн аж ахуйн нэгжийг дэмжихээр татварын болон НДШ-ээс чөлөөлөх, арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох, залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл хөтөлбөр боловсруулах зэрэг арга хэмжээг авч ажиллажээ.	37
2.5.1 Иргэн, аж ахуйн нэгжийн ажлын байрыг хадгалах зорилгоор төрөөс арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгожээ.	37
2.5.2 УИХ-аас гаргасан тогтоолын дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийг татварын болон НДШ-ийн чөлөөлөлтөд хамруулжээ.	38
2.5.3 Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийн хүрээнд 91 залууг хамруулж 89.0 сая төгрөгийн тэтгэлэг олгожээ	38
2.5.4 Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, мэдээ гаргаж тайлагнаагүй байна.	39
ДҮГНЭЛТ:	39
ЗӨВЛӨМЖ:	40
Холбогдох байгууллагын санал:	42

Товчилсон үгийн тайлбар

БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
БЭМС	Боловсрол эрүүл мэндийн сан
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ОБГ	Онцгой байдлын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ҮТП	Үйлдвэр технологийн парк

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХЦАХ	Хугацаат цэргийн албан хаагч
ХШҮДАХ	Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭХАХМ	Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан ХЭД зорилт, арга хэмжээний тоо	6
2	ХЭДС-ийн үйл ажиллагааны зардлын төлөвлөлт 2018-2021 он	10
3	ХЭДС-д хуваарилахаар төлөвлөсөн санхүүжилтийн харьцуулсан судалгаа	12
4	Төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт арга хэмжээний тоо	13
5	ХЭЗ-ийн дүрэм заасан чиг үүргийн харьцуулсан дүн	15
6	Сургалтын төвөөр дамжуулан иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгосон сургалтын тоо болон хамрагдсан иргэдийн тоо 2016-2021 он	19
7	Ажилд зуучлагдсан иргэдийн тоо 2016-2021 он	20
8	Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн статистик мэдээ	22
9	ХЭДС-ийн хөрөнгөөр олгосон санхүүгийн хэмжлэгийн судалгаа 2016-2021 он /хөтөлбөр тус бүрээр/	24
10	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн мэдээ 2016-2021 он	27
11	ХЭДС-ийн орлого, зарлагын харьцуулсан дүн 2016-2021 он	33
12	МСҮТ-ийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл 2016-2021 он	34
13	МСҮТ-ийн төсвийн зардлын судалгаа 2016-2021 он	35
14	МСҮТ-ийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа	36

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	ХЭД-ийн санхүүжилтийн эх үүсвэрийн судалгаа	11
2	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа /ганцаарчилсан/ 2016-2021 он	18
3	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн судалгаа 2016-2021 он	23
4	ХЭДС-д улсын төсвөөс олгосон санхүүжилтийн харьцуулсан судалгаа	32
5	ХЭДС-аас олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн судалгаа 2016-2021 он	33
6	Ажлын байрыг дэмжих зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлийн хэмжээ	37

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтыг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2021 оны 6 дугаар тогтоол, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.
Аудитын зорилт	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд аймаг сумын Засаг дарга, ХХҮГ, сумын хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, холбогдох төрийн байгууллагуудын 2016-2021 оны үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ /INTOSAI/-ы үндэслэн боловсруулсан Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит –Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах болон судалгааг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглалаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын талбарын ажлыг 2022 оны 3 сарын 7-ны өдрөөс 2022 оны 4 сарын 20 -ний өдөр хүртэл гүйцэтгэж, тайланг 2021 оны 5 сарын 5-ний өдрийн дотор танилцуулж, баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.
Хүндрэл бэрхшээл	Энэхүү аудит нь Төсвийн тухай хууль заасны дагуу ТТЗ, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн СТА-ын хугацаатай давхцаж, аудитыг цаг хугацаанд нь гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

БҮЛЭГ 1. Бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангаж төлөвлөлт хийгдээгүйгээс орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хөрөнгө батлагдаагүй байна.

1.1 Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ дунд, богино, урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй, хүрэх түвшин, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцоогүй байна.

1.1.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийн зорилго, зорилтууд уялджээ.

1.1.1.1 Монгол улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхээр тусгасан зорилт арга хэмжээ нь УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримтын бичгийн 2.6-т тусгасан зорилт арга хэмжээтэй уялдсан байна.

1.1.2 Бодлогын баримт бичгийн уялдаа хангагдахгүй байна

1.1.2.1 Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах зорилт, арга хэмжээ нь Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-той уялдаагүй байна.

1.1.2.2 Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулахаар зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээнд дараах зорилтыг тусгажээ. Хүснэгт №1

Үзүүлэлт	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагаа хөтөлбөр	Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагаа хөтөлбөр
Зорилго	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлнэ.	
Хэрэгжүүлэх зорилтын тоо:	13	4
Үзүүлэлт	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагаа хөтөлбөр	Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагаа хөтөлбөр
Зорилго	Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	
Хэрэгжүүлэх зорилтын тоо:	7	3

Хүснэгтээс харахад аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нээгдүүлэх зорилго дэвшүүлэхгүйгээр зорилт, арга хэмжээг төлөвлөжээ.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

1.1.2.3 Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дараах зорилтыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудтай уялдуулан төлөвлөсөн байна. Үүнд:

- *Хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинэ ажлын байр бий болгоно. (Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.14¹ дэх заалттай нийцсэн)*
- *Орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлнэ. (Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.10² дэх заалттай нийцсэн)*

1.1.2.4 Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй хэрхэн уялдаж байгааг авч үзвэл:

- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 2016-2020 оны сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй, СХС-ийн болон ХЭДС-ийн төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлээр л тодорхой зорилт тусгасан нь хангалтгүй байна.*
- *Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 1-2 зорилт, арга хэмжээг тусгасан*

1.1.2.5 ХХҮГ-ын Захиргаа удирдлагын хэлтсээс ХЭДС-ийн хөрөнгөөр тухайн жилд шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдийн тоо зэргийг сум тус бүрээр гаргаж сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулжээ.

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр зорилт, арга хэмжээ төлөвлөгдсөн боловч ерөнхий утга агуулгатай, нарийвчилсан, оновчтой биш байна. Бодлого оновчтой бус байх нь хөдөлмөрийн эрхлэлт, ажилгүйдлийн түвшин бууруулахад хүчин чармайлт гаргахгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд дорвитой ахиц гараагүйг олон судалгаа илтгэдэг. Иймээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, ажиллах хүчний ур чадвар, чанарыг сайжруулах зэрэг асуудлыг нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

1.1.3 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаагаар 25 ажил мэргэжилд 1,648 ажиллах хүчний илүүдэл үүсээд байна

1.1.3.1 Орон нутгийн 2015-2020 онд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд дүн шинжилгээ хийгдээгүй, нэгдсэн судалгаа боловсрогдоогүй байна. ХХҮГ-ын ХЭХ-ээс хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын судалгааг жил бүр ажиллах хүч, ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн зэрэг 8 үзүүлэлтээр статистик тоо мэдээ гардаг боловч хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд дүн шинжилгээ хийсэн судалгаа хийгдэхгүй байна.

¹ Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно.

² Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд бүрэн нийцүүлнэ.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

1.1.3.2 Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын статистик мэдээ, судалгааг өмнөх онтой харьцуулан гаргадаг ч дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг тодорхойлох, дүгнэлт гаргах зэрэг ажлуудад хангалтгүй ашигладаг байна.

1.1.3.3 Аймгийн Засаг даргын шийдвэрээр 2021 онд Швейцарын хөгжлийн агентлаг, ХХҮГ-тай хамтран хөдөлмөрийн зах зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулжээ.

1.1.3.4 Судалгаанд 340 аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчин, ажил хөдөлмөр эрхэлдэггүй зэрэг 4,230 иргэнийг хамруулсан байна. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанаас дараах үр дүн гарчээ. Үүнд:

- Аймгийн хэмжээнд 2022-2024 онд уул уурхай, төмөр замын, хөдөө аж ахуйн туслах ажилтан, хүнд даацын механизмын оператор, инженер зэрэг 20 ажил, мэргэжлийн 1,699 ажлын байрны эрэлтийг хангах ажиллах хүчний хомсдол үүсэх тооцоолол гарсан.
- Мөн дээрх онуудад эрх зүйч, тогооч, нягтлан бодогч, бага ангийн болон цэцэрлэгийн багш, барилгын засал чимэглэл, гагнуурчин, оёдол зэрэг 25 ажил мэргэжлийн 1,648 ажиллах хүчний илүүдэл үүсэх тооцоолол гарчээ.
- Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс авсан чанарын судалгааны дүнгээс ажилтнууд ажлын сахилга, хариуцлага алдсан, ачаалал даах чадваргүй, мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалтгүй гэх шалтгаанаар ажлаас халагдсан гэсэн үр дүн гарсан байна.

1.1.3.5 Судалгааны үр дүнгээс ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэргэжил олгох түргэвчилсэн буюу богино хугацааны сургалтыг хомсдол үүсэх магадлалтай ажил, мэргэжлийн дагуу түлхүү хэрэгжүүлэх шаардлага үүсжээ.

1.1.3.6 Аймгийн ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн нийцгүй байдал, ажиллах хүчний илүүдэл, хүний нөөцийн боломжийг хангалттай ашиглаж чадаж байгаа эсэхийг тодорхойлох оновчтой судалгаанууд хийгдээгүй байна. Тухайлбал Аймгийн МСҮТ-өөс 2015-2021 оны хичээлийн жилүүдэд оёдолчин мэргэжлээр 172, тогооч мэргэжлээр 340 иргэнийг төгсгөсөн бөгөөд ХХҮГ-аас дээрх мэргэжлүүдээр давхардуулан мэргэжил, ур чадвар олгох сургалтыг хэрэгжүүлсэн нь уг мэргэжлээр ажиллах хүчний илүүдэл үүсэхэд нөлөөлжээ. Үүнд:

- Оёдол, эсгүүрийн сургалтыг 4 удаа явуулж 91 хүн;
- Тогоочийн сургалтыг 5 удаа явуулж 95 хүн;

1.1.3.7 Иймд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг орон нутгийн түвшинд өргөн далайцтай боловсруулах, ажиллах хүчний хомсдолд дүн шинжилгээ хийн, эрэлтэд тохирсон мэргэжлээр иргэдийг сургах бодлого боловсруулж, хөдөлмөрийн зах зээлд үүсээд байгаа илүүдэл хүний нөөцийг зөв удирдах шаардлага үүссэн байна.

1.1.3.8 Мөн аймгийн МСҮТ хөдөлмөрийн зах зээлд илүүдэл үүсэж байгаа мэргэжлээр суралцагчдыг бэлтгэж байгаад дүн шинжилгээ хийж, сул ажлын байрны захиалга, ажиллах хүчний боловсрол, мэдлэг, ур чадварын шаардлагад нийцсэн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх талаар зохих шатны байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг тодорхой хугацаанд давтамжтайгаар хийх хөрөнгө санхүүгийн асуудлыг төсөвт тусгах орон нутагт хэрэгцээтэй ажиллах хүчнийг бэлтгэх ажлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх 5 жилийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт оновчтойгоор тусгаж, хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

1.1.4 Зарим байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгуулах саналаа тооцоо судалгаагүй, санхүүжих эх үүсвэр тодорхойгүйгээр хүргүүлжээ

1.1.4.1 Орон нутаг 2016-2020 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр тусгайлсан дэд хөтөлбөр боловсруулаагүй. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.13³, 5.2.13⁴-т заасны дагуу бүх талын оролцоог хангах хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага иргэдээс санал авсан байна.

1.1.4.2 ХХҮГ-аас үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар 5 зорилт, 13 арга хэмжээг хэрэгжүүлэх санал хүргүүлснээс үйл ажиллагааны хөтөлбөрт 2 зорилт 4 арга хэмжээг тусгажээ.

1.1.4.3 Мөн Сүхбаатар аймаг дахь МСҮТ-ээс 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт 6 зорилт арга хэмжээг тусгуулахаар санал хүргүүлсэн байна.

1.1.4.4 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4а⁵, 6.8.4б⁶-т заасны дагуу хөрөнгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тооцож ирүүлээгүй нь саналыг нэг бүрчлэн хөтөлбөрт тусгах боломжгүй байдлыг үүсгэжээ.

1.1.4.5 Иймээс МСҮТ-өөс Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналаас “Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш нарыг мэргэшүүлэх, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулах” гэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан байна.

1.1.4.6 Сүхбаатар аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахтай холбогдуулан иргэдийн оролцоог хангахын тулд иргэдээс Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар пейж хуудсаар дамжуулан санал, асуулга авчээ.

³ бүх талын оролцоог хангасан байх;

⁴ бүх талын оролцоог хангасан байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байхыг;

⁵ зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;

⁶ үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тооцож боловсруулсан байх.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

1.1.4.7 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3⁷-т төслийг олон нийтээр хэлэлцүүлэхээр заасан боловч Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэд олон нийтээр хэлэлцүүлээгүй байна.

1.2. Орон нутгийн төсөвт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө батлагдаагүй байна

1.2.1. Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө төлөвлөөгүй байна

1.2.1.1 Аймгийн ХХҮГ-аас тухайн жилийн ХЭДС-ийн төсвийн төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” жишигт нийцүүлэн боловсруулж ХХҮЕГ-т хүргүүлсэн байна.

1.2.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээнд шаардлагатай санхүүжилтийг хөтөлбөр тус бүрээр тооцож 2020 онд 925.8 сая, 2021 онд 941.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

1.2.1.3 Харин жижиг зээл олгох, бүртгэл мэдээлэл, сурталчилгаа, гарын авлага бэлтгэх зэрэг бусад үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг төлөвлөсөн эсэх нь тодорхойгүй байна. Бусад үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн зардлыг нэр төрөл тус бүрээр нь хүснэгтээр харуулав. Хүснэгт №2

д/д	зардлын нэр	Зарцуулахаар төлөвлөсөн мөнгөн дүн /сая төгрөг/		
		2018 он	2020 он	2021он
1	Жижиг зээл	250.0	-	-
2	Хүүгийн хөнгөлөлт	3.5	2.0	2.0
3	Хүүхдийн ХТХ устгах	6.0	4.7	
4	Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл	4.5	6.5	6.0
5	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим	6.5	2.0	3.0
6	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	2.5	5.0	8.0
7	Чадавх бэхжүүлэх сургалт	6.0	6.0	8.0
8	Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	11.0	5.5	10.0
9	Хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээ	15.0	8.0	10.0
10	Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	2.0		
11	гарын авлага хэвлэмэл материал	4.0	4.0	3.0
НИЙТ ДҮН		311.0	43.7	50.0

1.2.1.4 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөсөн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төлөвлөж, батлуулаагүй байна.

⁷ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

1.2.1.5 Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажиллах хүчний хэрэгцээг хангах, амьдралын түвшин дээшлүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутгийн төсөвт хөрөнгө төлөвлөгдөхгүй байгаа нь бодлого оновчгүй, хүчин чармайлт гаргах сонирхолгүй, макро эдийн засгийн түвшинд асуудлаа зөв төлөвлөхгүй байгааг илтгэж байна. Тухайлбал 2020-2021 онд ХЭД чиглэлээр төсвийн санхүүжилтийн хурд 1.6 хувь, харин ажлын байрны өсөлтийн хурд 0.5 хувьтай байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зарцуулсан хөрөнгийн үр ашиг хангалтгүй, үр дүн гарахгүй байгааг харуулжээ.

1.2.1.6 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг эдийн засгийн тооцоо судалгаанд тулгуурлан төлөвлөж, ИТХ-аар батлуулан, үр дүнг тооцох нь зүйтэй байна.


1.2.2. Бодлогын баримт бичигт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг тусгажээ

1.2.2.1 Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдсан зорилт арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18.2.1-т заасны дагуу улс орон нутгийн төсөв болон ХЭДС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

1.2.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч нарийвчилсан тооцоо судалгаагүй, чанар үр дүн гарах эсэх нь тодорхойгүй төлөвлөлт хийгджээ.

1.2.2.3 Дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн оновчтой тодорхойлж байх нь тухайн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

1.2.2.4 Аймгийн ХХҮГ нь 2020, 2021 оны ХЭДС-ийн төсвийн төслөөр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дараах байдалтай байна. График 1



Графикаас ХЭДС-ийн санхүүжилтийг 3 эх үүсвэрээр бүрдүүлэхээр төлөвлөсөн. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, ХБИ ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагын төлөх төлбөрийн орлого нь нэгдсэн дансанд төвлөрсөн бөгөөд захиран зарцуулах эрхгүй орлогын

эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

1.2.3. Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

1.2.3.1 Аймгийн ХЭДС-д ХХҮЕГ-ын даргын тушаалаар тухайн онд зарцуулах төсвийг хуваарилж баталсан байна. ХЭДС-д хуваарилахаар баталсан хөрөнгийг он тус бүрээр харуулав. Хүснэгт 3

Он	Хуваарилсан мөнгөн дүн /сая төгрөгөөр/			
	Хөтөлбөрт зарцуулах	Жижиг зээл	Итгэлийн зээл	Бусад үйл ажиллагаанд зарцуулах
2016	360.5	-	-	27.5
2017	686.5	350.0	-	48.3
2018	690.4	600.0	-	34.9
2019	940.0	301.4	200.0	59.9
2020	523.4	-	-	39.8
2021	450.3	-	-	105.2

1.2.3.2 Хүснэгтээс 2019 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хамгийн их төсөв хуваарилагдсан бол 2016 онд хамгийн бага санхүүжилт олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн хэлтэс, Халамжийн хэлтэстэй үйл ажиллагаагаа нэгтгэж байгаатай холбоотой санхүүжилтийг түр зогсоосон нь нөлөөлжээ.

1.2.3.4 Жижиг зээлд 2017-2019 онд ХЭДС-д 1,233.0 сая төгрөгийн санхүүжилтэд хуваарилахаар баталсан боловч уг санхүүжилтийг арилжааны банкнуудад шууд олгосон байна.

1.2.3.5 Батлагдсан төсвийг бүрэн санхүүжүүлсэн эсэхийг авч үзэхэд 2016 оноос бусад онуудад санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу бүрэн олгоогүй бөгөөд 2017-2021 онд ХЭДС-д хуваарилахаар батлагдсан санхүүжилтийг 2.6-99.7 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлжээ.

1.2.3.6 Аймаг, сумын төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор дараах хөрөнгийг хуваарилсан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2017 оны А/652 дугаар захирамжаар ҮТП-аар дамжуулан ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход 500.0 сая, 2018 оны А/354 дугаар захирамжаар 391.0 сая төгрөгийг хуваарилж санхүүжүүлсэн.
- Аймгийн Засаг даргын шийдвэрээр 2020 онд Онгон сумын цөөн малтай иргэдийг малжуулах төсөлд 20.0 сая, 2021 онд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийхэд 10.0 сая төгрөг тус тус хуваарилсан.
- Сүхбаатар сумын ИТХ-ын 2017 оны 28 дугаар тогтоолоор Боловсрол эрүүл мэндийн сангаас 70.0 сая төгрөгийг малжуулах хөтөлбөрт зарцуулахаар баталж санхүүжүүлсэн байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

1.2.3.7 Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1⁸ дүгээр хавсралтаар баталсан журмын 2 дугаар зүйлийн 2.3-т орон нутгийн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүйг ХЭДС-д хуваарилахаар тусгасан боловч аймаг, орон нутгийн төсвөөс хөрөнгө батлаагүй байна. Төсвийн захирагчид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зорилтот түвшин, зарлагын үр ашиг, үр дүнгийн талаар дүн шинжилгээ хийгээгүй, хоорондын мэдээлэл дамжуулалт хангалтгүй, нэгдсэн бодлогогүй байгаагаас санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг алдаж байна.

1.2.3.8 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гадаад, дотоод эх үүсвэрээр оновчтой төлөвлөх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр дэд хөтөлбөрүүдийг боловсруулах нь зүйтэй юм.

1.3. Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаагүй байна

1.3.1. Төр захиргааны байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг уялдуулж тусгаагүй байна

1.3.1.1 Аймгийн ЗДТГ, ХХҮГ, ГБХЗХГ-ийн 2019-2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээг харьцуулж үзэхэд дараах үр дүн гарч байна. Хүснэгт 4

Д/д	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан					
		2019		2020		2021	
		Зорилт	Арга хэмжээ	Зорилт	Арга хэмжээ	Зорилт	Арга хэмжээ
1	ЗДТГ	1	5	2	2	1	2
2	ХХҮГ	4	16	9	12	7	28
3	ГБХЗХГ	-	-	1	1	1	2

1.3.1.2 Аймгийн ХХҮГ нь чиг үүргийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг нэг бүрчлэн тусгаж төлөвлөж байгаа ЗДТГ нь засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт арга хэмжээг ерөнхий байдлаар багцлан төлөвлөжээ.

1.3.1.3 ГБХЗХГ нь Залуучуудын хөгжлийг дэмжих, оролцоог хангах замаар тэдэнд гэр бүлийн боловсрол олгож, амьдрах арга ухаанд сургах үндсэн чиг үүргийн хүрээнд зорилт арга хэмжээг төлөвлөж байгаа боловч хөдөлмөр эрхлэлтийн талаар тодорхой арга хэмжээг төлөвлөөгүй байна.

1.3.1.4 Харин МСҮТ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд иргэдэд ажил, мэргэжлийн богино болон урт хугацааны сургалт явуулж, мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх, төгсөгчдийг ажлын байраар хангах зорилт арга хэмжээг тусгасан нь ХХҮГ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй уялдаж байна.

⁸ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

1.3.1.5 Мөн Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний тав дахь хөтөлбөр” –ийн хүрээнд аймгийн ЗДТГ, МХГ, Онцгой байдлын газар зэрэг байгууллагуудтай хамтран хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр ажил олгогч, ажилтан аюул эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадал төлөвшүүлэх сургалт дадлагыг хамтран хэрэгжүүлжээ.

1.3.1.6 Хэдийгээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч ГБХЗХГ нь залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиг үүргийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. Иймд уг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, ХХҮГ-тай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.3.1.7 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагууд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулан тусгаж байх нь зүйтэй юм.

1.3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн онцлогт тохирсон бодлогогүйгээс ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийг байнгын ажлын байраар хангаж чадахгүй байна

1.3.2.1 Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 сарын 4-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын хавсралтаар “Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028” бодлогын баримт бичгийг баталжээ.

1.3.2.2 Бодлогын баримт бичгийн “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан технологийн дэвшилттэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх, хувийн хэвшилтэй хамтран төгсөгчдийг ажлын байраар хангах зорилт дэвшүүлж” уг зорилтыг хангахаар 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.3.2.3 Аймгийн Засаг дарга 2021 онд А/308 дугаар захирамж гарган бүс, орон нутгийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар аймагт 2021-2024 онд ЖДҮ-ийг хөгжүүлэх дараах тэргүүлэх чиглэлийг баталсан байна. Үүнд:

1. Малын тэжээл тариалалт, үйлдвэр;
2. Ноос, ноолуур угаах үйлдвэр;
3. Арьс шир, дайвар бүтээгдэхүүн боловсруулах;
4. Төмс, хүнсний ногоо, нарийн ногоо тариалалт, хүнсний ногоо хатаах даршлах үйлдвэр;
5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, эрчимжсэн саалийн үнээний ферм;
6. Барилгын материал үйлдвэрлэл (хөнгөн блок, бетон зуурмаг гэх мэт);
7. Орон нутгийн онцлог бүхий бэлэг дурсгалын зүйлс;
8. Аялал жуулчлал зэргийг хөгжүүлэхээр тэргүүлэх чиглэлээр баталсан байна.

1.3.2.4 Онгон, Сүхбаатар, Баяндэлгэр, Асгат зэрэг сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг сүү сүүн бүтээгдэхүүн, фермерийн аж ахуй, блок үйлдвэрлэл зэрэг 8 чиглэлээр тодорхойлж ИТХ-аар батлуулсан байна.

1.3.2.5 Аймаг, сумын Засаг дарга, түүний ажлын алба орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг оновчтой тодорхойлоогүйгээс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, зорилт арга хэмжээ үр дүнд хүрч чадахгүй байна. Тухайлбал:

- Аймгийн ИТХ-ын 2017 оны 36 дугаар тогтоолоор орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн шинэ дэвшилтэд технологи дамжуулах, нэвтрүүлэх нутагшуулах, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийн парк чөлөөт бүсийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх зорилго бүхий “Сүхбаатар хөгжил УТП” ОНӨААТҮГ-ийг байгуулжээ. Тус паркаар дамжуулан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг иргэн аж ахуйн нэгж байгууллагад олгож сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, сав баглаа боодол, оёдол, мах махан бүтээгдэхүүн боловсруулах зэрэг үйлдвэрийг байгуулахаар 10 төсөл шалгаруулж үйл ажиллагааг эхлүүлсэн боловч ихэнх төсөл хөтөлбөр зогссон байна.
- Мөн хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогогүйгээс төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээд ажлын байр нэмэгдүүлэх, өргөтгөх, иргэдийн байнгын ажлын байраар хангах зэрэг асуудал орхигдож зөвхөн өөрийгөө санхүүжүүлэх хэмжээний өрхийн үйлдвэрлэл эрхэлж байна.

1.3.2.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээг боловсруулахдаа тухайн орон нутгийн онцлог хэрэгцээ, өмнө хэрэгжсэн арга хэмжээнүүдийн үр дүнг үнэлэхгүйгээр боловсруулж байгаа нь учир дутагдалтай байна.

1.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна

1.3.3.1 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 2 дугаар тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэлийн зөвлөлийн дүрмийг баталсан байна. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл дүрмийн 3.1-т заасны дагуу 9 хүний бүрэлдэхүүнтэй Засаг даргын 2021 оны А/157 дугаар захирамжаар шинэчлэн томилогджээ.

1.3.3.2 Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байдлыг харуулав.

Хүснэгт 5

д/д	Дүрэмд заасан хэрэгжүүлэх үүрэг	Чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байдал
1	Төсвийн тухай хууль Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.2 дахь заалтын дагуу орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар зарцуулагдах хөрөнгийг төсөвт жил бүр тусган батлуулах	Зөвлөл орон нутгийн төсөвт ХЭД зориулалтаар зарцуулах хөрөнгийг саналыг хүргүүлдэг боловч ИТХ-аар баталдаггүй.
2	Аймагт ХЭ-ийн талаар баримтлах бодлого, холбогдох хөтөлбөрүүд, түүнчлэн ХЭДС болон аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулан батлуулах ажлыг санаачлан зохион байгуулах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж батлуулаагүй.
3	ХЭД дэд сангийн орлого, зарлагын явц байдал, үүний дотор ХЭДС-ийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих	Зээлийн эргэн төлөлт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьдаг.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

4	Тухайн орон нутагт хэрэгжсэн ХЭД үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах	Зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж тайлагнаж байгаа боловч үр дүнд үнэлгээ хийж санал дүгнэлт гаргаагүй.
5	ХЭД үйл ажиллагаанд нийгмийн болон төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмуудыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжих, иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах	ХЭД төсөл хөтөлбөрт иргэдийн оролцоог хангахыг зорьдог боловч ил тод байдал буюу төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийг мэдээлэх талаар хангалтгүй ажиллаж байна.
6	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж, хэрэглэгчид үйлчлүүлэгчдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах	Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 2021 онд Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран гүйцэтгэсэн. Төсөв санхүүгийн дутагдалтай байдлаас шалтгаалан давтамжтайгаар хэрэгжүүлж чадаагүй.
7	ХЭ-ийн асуудлаар төрийн захиргааны үйлчилгээний байгууллага, ялангуяа мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг дунд үйлдвэр, ХАА, гэр бүл залуучууд хөгжлийн болон бусад холбогдох асуудал эрхэлсэн байгууллага, бусад хороо зөвлөлүүдтэй үйл ажиллагаагаа уялдуулах	ХХҮГ-аас МХГ, ГБХЗХГ, МСҮТ-тэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байгаа бөгөөд ХЭД зөвлөл хэрхэн уялдуулсан нь тодорхойгүй байна.
8	Тухайн орон нутагт хэрэгжсэн ХЭД үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг ХЭД ҮЗ-д жил бүрийн 1 дүгээр сард ирүүлж байх	Жил бүр зөвлөлийн ажлын тайланг хүргүүлж байна.
9	ҮЗ-ийн ажлын албанаас гаргасан аргачилсан удирдаж, зөвлөмжийг үндэслэн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, томилсон байгууллагадаа ажлаа тайлагнах болон удирдах зохицуулах, хяналт үнэлгээ хийхдээ ашиглах шалгуур үзүүлэлт зэргийг үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж хэрэгжүүлэх	Зөвлөл 2017-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд гишүүдийн хариуцах арга хэмжээг тодорхой хуваарилсан байна. Мөн 2017-2018 онуудад ХЭД чиглэлийн хөтөлбөрийг зөвлөлийн гишүүдэд хуваарилан хариуцуулсан байна. Харин 2021 онд гишүүдэд хариуцан ажиллах байгууллагуудыг хуваарилсан.

1.3.3.3 Хүснэгтэн мэдээллээс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах талаар хангалтгүй ажилласан байна.

1.3.3.4 Хөдөлмөр эрхлэлтийн аймаг нийслэлийн зөвлөлийн дүрмийн 3.1⁹-д зөвлөлийн дарга нь тухайн аймгийн Засаг дарга байхаар зохицуулсны дагуу зөвлөлийн даргаар аймгийн Засаг дарга томилогдсон боловч үйл ажиллагааг Засаг даргын нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга удирдан ажиллаж байна.

1.3.3.5 Мөн дүрмийн 3.5-д хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдахаар заасан боловч аймгийн зөвлөл 2020, 2021 онуудад тус бүр нэг удаа хуралджээ.

1.3.3.6 Аймгийн засаг дарга дүрэмд заасны дагуу зөвлөлийн дарга хийх нь зүйтэй бөгөөд энэ нь хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх

⁹Зөвлөлийн дарга нь тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга байх бөгөөд гурван талын төлөөлөгчдийн тоо ажил байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

чиглэлээр авах арга хэмжээнүүдэд анхаарал хандуулах, үр дүнг хэмжихэд илүү хяналттай болох эерэг нөлөөтэй юм.

1.3.4 Бодлогын зарим зорилт арга хэмжээний биелэлтийг, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд үндэслэн үнэлээгүй байна

1.3.4.1 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1.3.4.2 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс хяналт шинжилгээ үнэлгээ хийж дунджаар 92.5 хувьтай хэрэгжсэн гэж үзжээ.

1.3.4.3 Харин аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлэн 3 зорилт 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 2021 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр хөтөлбөрийн хэрэгжилтийг 87.5 хувьтай үнэлсэн байна.

1.3.4.4 Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ болон хэрэгжилтийг тайлагнасан байдлыг авч үзвэл:

1.3.4.5 Хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлж, зорилтын хүрэх үр дүнг тооцоогүйгээс биелэлтийг үр дүнтэй харьцуулан тайлагнаж чадаагүй байна. Тухайлбал: Аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус бүр нэг зорилт арга хэмжээний хэрэгжилтийг авч үзэхэд;

1. 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: “Өрх бүрд 1 ажлын байр хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, ажилгүйдлийн түвшинг бууруулна.” гэсэн зорилтын хэрэгжилтийг тайлагнахдаа ажилгүйдлийн түвшинг хэрхэн буурсан, өрх бүрд 1 ажлын байр хөтөлбөрийг боловсруулсан эсэх зэрэг зорилтыг хэрэгжүүлсэн талаар тайлагнаагүй, зөвхөн тоочих хэлбэрээр тайлагнасан.
2. 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт: “Ажилтай төгсөгч хөтөлбөрийг хэрэгжүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” арга хэмжээг төлөвлөж 2020-2021 оны хичээлийн жилд төгссөн сурагчдын 71.5 хувь нь ямар нэг ажил хөдөлмөр эрхэлж /малчин, оюутан гэх мэт/ байгаагаар тайлагнасан боловч төгсөгчдөөс мэргэжлийн чиглэлээр 15.6 хувь ажиллаж байгаа статистик гарсан байна. Мөн ажил төгсөгч хөтөлбөр боловсруулахаар үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ч одоогоор уг хөтөлбөрийг боловсруулж батлуулаагүй байна.

1.3.4.6 Дээрх 2 арга хэмжээний хэрэгжилтийг ХШҮХ-ээс 100 хувь хэрэгжсэнээр үнэлсэн. Эндээс дүгнэж үзвэл үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнтэй харьцуулж дүн шинжилгээ хийж, үнэлгээгүй байна.

1.3.4.7 Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

бодлого”, 2016 оны 156 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

1.3.4.8 ХШҮХ-ээс бодлогын баримт бичгийн биелэлтийг зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнд тулгуурлан тухайн байгууллагын статистик мэдээ, тайлантай тулган үнэлж дүгнэх нь зүйтэй юм.

БҮЛЭГ2: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулсан боловч төсөл, хөтөлбөр үр дүнтэй хэрэгжээгүй, иргэдэд үзүүлсэн үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн системд давхардуулан бүртгэжээ

2.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг тооцож, тайлагнаагүй байна

2.1.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамрагдсан иргэдийг мэдээллийн системд давхардуулан бүртгэжээ

2.1.1.1 Ганцаарчилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг 2016-2021 онд давхардсан тоогоор 1,497 иргэн үзүүлжээ. Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө, мэдээллээр хангасан байдлыг он тус бүрээр харуулбал: График 2



Графикаас харахад 2021 онд ганцаарчилсан зөвлөгөө хамгийн их үзүүлэлттэй байгаа бол 2017 онд хамгийн бага үзүүлэлттэй байна. Ажлын чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа нь 2021 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа сумдын Хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн өөрсдийн ажлын чиг баримжаа олгох, зөвлөгөө

өгсөн иргэдийн мэдээллийг LMIS программд оруулах эрхийг тухайн жилд олгосон нь нөлөөлсөн байна.

2.1.1.2 LMIS программаас авсан мэдээллээс үзэхэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө олгосон иргэдийг мэдээллийн системд 2020-2021 онд давхардуулан бүртгэж статистик тоон мэдээг буруу гаргасан байна. Тухайлбал:

- 2020 он ганцаарчилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгсөн иргэдийг 101 удаа /давхардсан тоогоор/, 2021 онд 16 иргэнийг тус тус давхардуулан бүртгэсэн.

2.1.1.3 Мөн дээрх программд бүртгэсэн мэдээллээс харахад 2017 онд Баруун-Урт, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, 2019 онд Баруун-Урт, Дарьганга, Түмэнцогт,

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Эрдэнэцагаан сумдаас бусад сум иргэдэд ажлын чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах ажлыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.1.4 Сумын мэргэжилтэнд LMIS программд ажлын чиг баримжаа олгох зөвлөгөө, мэдээллээр хангасан иргэдийг бүртгэх эрхийг 2020 оноос эхлэн өгсөн бөгөөд түүнээс өмнөх онуудад уг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн бүртгэлийг ХХҮГ-ийн хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн байна. Иймд ХХҮГ-ын ажил зуучлал, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэргэжилтэн сумаас ирүүлсэн дээрх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг нэгдсэн системд бүрэн гүйцэт оруулаагүй байх эрсдэл үүсжээ.

2.1.1.5 Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмжид мэргэшсэн зөвлөх эрх авсан хөдөлмөрийн ажилтан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг иргэдэд үзүүлэхээр заасан байна. Гэтэл 5 сумын ХЭХАХМ-үүд эрх аваагүй боловч үйлчилгээ үзүүлж байгаа нь иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй байх эрсдэл үүсэж байна.

2.1.1.6 Иймд ажил үйлчилгээг үзүүлэх эрхгүй мэргэжилтнийг дээрх чиглэлийн сургалтад хамруулж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлж байх нь зүйтэй юм.

2.1.1.7 Сургалтын эрх бүхий байгууллагаар дамжуулан ерөнхий боловсролын сургуулийн сурагч, ХЦАХ-д болон иргэд зэрэг 3,342 иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөөг хүргүүлсэн байна. Сургалтын төвөөр дамжуулан ажил мэргэжлийн чиг баримжаа олгосон сургалтын мэдээллийг он тус бүрээр харуулав.

Хүснэгт 6

№	Он	Сургалтын байгууллагын нэр	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	Хамрагдсан хүний тоо
1	2016	Монголын ажил мэргэжлийн зөвлөхүүдийн холбоо	3.0	250
		Оюуны язгуур НҮТББ	2.4	400
2	2017	Чадамж боломж ХХК	2.1	356
3	2018	Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн НҮТББ	2.0	334
		Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн НҮТББ	0.3	22
		Монголын экспорт импортыг дэмжих үндэсний төв	2.7	454
4	2019	Сургалт судалгааны оюун тамир төв ТББ	1.7	142
		Сургалт судалгааны оюун тамир төв ТББ	3.5	589
5	2021	Вэст метод ХХК	2.1	350
		Дарь овооны эзэд НҮТББ	1.4	237
		Дарь овооны эзэд НҮТББ	0.7	55
		Сүхбаатар аймаг дахь МСҮТ	0.9	153
ДҮН			22.9	3,342

2.1.1.8 Хүснэгтээс харахад 2020 оноос бусад онуудад бүлгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг явуулсан харагдаж байна. Сургалтын төвөөр

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

дамжуулан сурагчдад ажил мэргэжлээ зөв сонгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангаж ямар үр дүнд хүрч байгаад дүн шинжилгээ хийж үр дүнг үнэлээгүй байна.

2.1.1.9 Цаашид ганцаарчилсан болон бүлгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааны үр дүнг харилцагч байгууллагын хариуцсан /сургалтын менежер, нийгмийн ажилтан гэх мэт/ албан тушаалтантай хамтран дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, чиг баримжаа олгох сургалт сурталчилгааг ямар хэлбэрээр явуулбал илүү үр дүнд хүрэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийж, төлөвлөж байх нь зүйтэй байна. Мөн ажил мэргэжлийн чиг баримтаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний нэгдсэн стандартгүй, үйлчилгээг бүрэн үзүүлдэг эсэх нь эргэлзээтэй байна.

2.1.1.10 Аймгийн хэмжээнд 2016-2021 онд 5,177 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилжээ. Иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байдлыг он тус бүрээр харуулав. Хүснэгт 7

Он	ажилд зуучилсан хүний тоо	Үүнээс		
		байнга	түр	төсөл, хөтөлбөрт хамрагдсан
2016	769	204	539	26
2017	1,135	315	674	146
2018	944	200	656	88
2019	775	242	447	86
2020	850	320	310	220
2021	704	282	243	179
НИЙТ ДҮН	5,177	1,563	2,869	745

Хүснэгтээс харахад 2017 онд хамгийн олон иргэний түр болон байнгын ажлын байранд зуучилсан харагдаж байгаа бол 2021 онд хамгийн бага буюу 704 хүнийг ажилд зуучилсан байна. Энэ нь тус дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна гэж үзлээ. Нийт ажилд зуучлагдсан иргэдийн 1,563

буюу 30.2 хувь нь байнгын ажлын байранд зуучлагдсан байна. Харин 2017-2021 онд Эл Эм Цахиурт овоо ХХК 173, Хун-Ша И Жаны ХХК 234 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан нь нийт ажилд зуучлагдсан иргэдийн 7.8 хувийг эзэлж байна.

2.1.1.11 Түр ажлын байранд зуучлагдсан иргэд нь ихэнх нь нийтийн хамарсан ажил болон ямаа самнах, хадлан тэжээл бэлтгэх, ногоо хураалт зэрэг улирлын чанартай 10-14 хоногийн ажилд зуучлагджээ.

2.1.1.12 Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн мэдээллийн санд (LMIS программ) дараах албан тушаалтныг ажлын байранд зуучилснаар бүртгэсэн алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- Улс төрийн сонгуулийн үр дүн сумын болон багийн Засаг даргаар томилогдсон, ИТХ-ын дарга, БИНХ-ын даргаар томилогдсон ажиллаж байгаа иргэдийг ажилд зуучилснаар бүртгэсэн байна. Тухайлбал: сонгуулийн үр дүнгээр төрийн улс төрийн албан тушаалд томилогдсон 2016 он 5, 2017 он 31, 2020 онд 2, 2021 онд 16 төрийн улс төрийн албан тушаалтныг;
- Төрийн тусгай буюу цэрэг, онцгой байдлын албан томилогдон ажиллаж байгаа иргэдийг ажилд зуучилснаар бүртгэж байна. Тухайлбал: 2016 онд Хилийн-р ангид гэрээт хилчнээр томилогдсон 7, ОБХ-ийн аврагч, гал сөнөөгч 18, 2018 онд ОБХ-ийн бүлгийн дарга, аврагчаар томилогдсон 12 албан хаагчийг;

- Төрийн захиргааны албан тушаалд дэвшсэн болон төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад тэнцэж албан тушаалд томилогдсон иргэдийг ажилд зуучилснаар бүртгэсэн байна. Тухайлбал: 2017 онд сумын ЗДТГ-ын дарга, 2018 онд сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, цэцэрлэгийн эрхлэгч, 2021 онд МХГ-ын улсын байцаагч, сургуулийн захирал, нягтлан бодогч зэрэг албан тушаалд сэлгэн болон дэвшин томилогдсон 13 албан тушаалтныг байнгын ажлын байранд зуучилснаар бүртгэж мэдээлсэн байна.

2.1.1.13 Улс төрийн, төрийн тусгай албан хаагч, төрийн албаны сонгон шалгаруулалтаар болон албан тушаалд сэлгэн, дэвшин томилогдсон иргэдийг байнгын ажлын байранд зуучилснаар бүртгэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹⁰ дэх заалтад нийцээгүй шийдвэр болсон байна.

2.1.1.14 Хөдөлмөрийн мэргэжилтнүүд чанарын үзүүлэлтийг тогтоож үнэлдэггүй, хөтөлбөр арга хэмжээний үр нөлөөг хэмжих мэдээлэл цуглуулдаггүй, тооны араас хэтэрхий хөөцөлдөж байгаа нь мэдээлэл алдаатай гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн ХЭДХ-ийн хувьд хамрагдах иргэдийн тооны хязгаарыг тавьж өгч байгаа нь хөтөлбөрийн хамрах хүрээ, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

2.1.2. Аймгийн хэмжээнд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн эзлэх хувь улсын дунджаас өндөр байна

2.1.2.1 ХХҮГ-ийн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс нь LMIS нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг ашиглан бүртгэл мэдээллийг нэгтгэн гаргаж байна.

2.1.2.2 Уг нэгдсэн мэдээллийн системийг 2014 оноос ашиглаж байгаа бөгөөд ашиглалтын явцад дараах хүндрэл бэрхшээл гарч байна. Тухайлбал:

- Хэт ачаалсан үед /нэг зэрэг олон хүн хандах/ гацах, мэдээллийн системд нэвтрэхгүй болох;
- Сумын ХЭХАХМ мэдээллийн системийн хөдөлмөр эрхлэлт, ганцаарчилсан зөвлөгөө, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гэсэн 2 цэсэд нэвтрэх эрхтэй /ганцаарчилсан зөвлөгөө, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цэст нэвтрэх эрхийг 2021 оноос өгсөн/;
- Мэдээллийг файлаар татах эрхийг зөвхөн ХХҮГ-т ажиллаж байгаа албан тушаалтанд өгсөн тул сум орон нутгийн мэдээллийг татан авах, хайлт хийх боломжгүй;
- Байнгын ажлын байранд зуучлагдсан иргэний мэдээллийн оруулахад хэт олон мэдээлэл оруулдаг;
- Зарим ажил, мэргэжлийн сонголтыг оруулаагүйгээс ижил төсөөтэй ажил мэргэжлээр оруулж хэрэглэдэг;
- Огт мэргэжилгүй иргэний мэдээллийг оруулахад заавал мэргэжил бүртгэх сонголттой тул иргэний мэдээллийг буруу бүртгэх эрсдэл үүсэж байна;

2.1.2.3 Уг ашиглаж байгаа нэгдсэн системд хөдөлмөр эрхлэлтийн мэдээ тайлан буруу бүртгэгдэж байна. Үүнд:

- ХЭДС, СХС, Сүхбаатар хөгжил ҮТП-ийн дэргэдэх ЖДҮ-ийн хөгжүүлэх сангаар дамжуулан төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийг программд шинэ ажлын

¹⁰ Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь бүртгэсэн ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

байр нэмэгдсэнээр бүртгэгдэж байгаа боловч төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй, иргэд одоог хүртэл ажил хөдөлмөр эрхлэгчээр бүртгэлтэй байна.

- Төрийн болон хувийн хэвшилд байнгын ажлын байранд зуучлагдсан иргэд тухайн байгууллагад 2-3 сар ажиллаад чөлөөлөгдөж одоогоор ажилгүй хөдөлмөр эрхлэхгүй байхад ажил эрхэлж байгаа иргэнээр бүртгэлтэй байна.
- Өөр аймаг, хотод ажилд зуучлагдсан иргэдийг харьяаллаар нь ажилд зуучлагдсанаар бүртгэж байна. Тухайлбал: Сүхбаатар аймгийн иргэн Дорнод аймгийн ХХҮГ-аар ажилд зуучлуулахад Сүхбаатар аймгийн ХХҮГ-аас зуучилснаар бүртгэж байна.

2.1.2.4 Эндээс дүгнэхэд хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн тоо мэдээ бодитой бус, алдаатай байх эрсдэл өндөр бөгөөд нийгэм эдийн засагт сөрөг үр нөлөөтэй байх магадлалтай юм.

2.1.2.5 ХХҮГ-ийн мэдээгээр 2016-2021 онд шинээр ажилд орсон нийт 4,625 иргэнийг байнгын болон түр ажлын байранд орсноор мэдээлсэн байна. Харин аймгийн НДХ-ээс авсан судалгаагаар 2016-2021 онд давхардсан тоогоор 210 ажил олгогч 689 иргэнийг шинээр ажлын байраар хангаж НДШ-ийг төлсөн байна. Дээрх судалгааг харьцуулж үзэхэд 3,936 иргэний зөрүү үүсэж байгаа бөгөөд албан бус хөдөлмөр эрхлэлт байх магадлалтай байна.

2.1.2.6 Мөн 2016-2021 онд ажилд зуучлагдсан иргэдийн мэдээг, LMIS нэгдсэн мэдээллийн сангийн татан авсан судалгаагаар харьцуулж үзэхэд 13 хүнээр зөрүүтэй мэдээлжээ.

2.1.2.7 Аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн зарим статистик тоон мэдээг www.1212.mn сайтаас татан авч дүн шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн гарч байна. Хүснэгт 8

Үзүүлэлт	Он					
	2016	2017	2018	2019	2020	2021
Нийт хүн ам	59,810	61,131	62,322	63,182	63,822	64,662
Ажиллагчид	27,011	26,105	26,797	28,283	27,484	27,485
хөдөлмөр эрхлэлтийн түвшин	67.1	63.2	65.7	67.6	67.2	71.4
Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо	2,561	4,128	5,109	18,847	16,053	-
хувийн жин	9.4	15.8	19.0	66.6	58.4	-

2.1.2.8 Хүснэгтээс харахад 2021 онд хөдөлмөр эрхлэлтийн түвшин хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016-2021 онуудын дунджаар авч үзэхэд 67.0 хувьтай, энэ нь зүүн бүс нутгийн дундаж үзүүлэлтээс 10.6 хувь, улсын дундаж үзүүлэлтээс 12.2 хувиар өндөр үзүүлэлттэй байна.

2.1.2.9 Албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгааг авч үзэхэд 2019-2020 оны судалгаанд хөдөө аж ахуйн салбарт /малчин иргэд/ хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг оруулан тооцсон уг үзүүлэлтээр нийт ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 58.4-66.6 хувь нь албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа судалгаа байна. Энэ нь албан бус хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын дунджаас 16.9-25.1 хувиар өндөр үзүүлэлттэй. Харин хөдөө аж ахуйн бус салбарт жилд дунджаар 3,560 иргэн албан бус хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд энэ нь улсын дундаж


“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

үзүүлэлтээс 8.8 хувь, зүүн бүсийн дунджаас 8.9 хувиар тус тус доогуур үзүүлэлттэй байна.

2.1.2.10 Цаашид аймгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд Статистикийн хэлтсээс хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гаргасан мэдээ судалгаанд дүн шинжилгээ хийж, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх, албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг байнгын ажлын байранд зуучлах бодлого боловсруулж, байх нь зүйтэй юм.

2.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцож тайлагнаагүй байна

2.1.3.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ буюу ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ болон ажил зуучлах үйлчилгээнд нийт 48.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулсан хөрөнгийг төлөвлөгөө гүйцэтгэлээр харуулав. График 3



2.1.3.2 Графикаас харахад 2016-2021 онд Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэхэд 79.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 60.6 хувь буюу 48.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийт зарцуулсан хөрөнгөний 47.9 хувь буюу 23.1 сая төгрөгийг ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд, 52.1 хувь буюу 25.1 сая төгрөгийг ажилд зуучлах үйлчилгээнд тус тус зарцуулжээ.

2.1.3.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 оны зарцуулалтад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ: Уг үйлчилгээг 2016-2021 онд нийт 5,327 иргэнд үзүүлж 43.9 сая төгрөг буюу дунджаар нэг иргэнд 0.008 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Харин гүйцэтгэлээр 4,218 иргэнд уг үйлчилгээг үзүүлж 23.1 сая төгрөг буюу дунджаар нэг иргэнд 0.005 сая төгрөг зарцуулж 52.6 хувьтай хэрэгжсэн байна. Мөн төлөвлөгөө гүйцэтгэлийг он тус бүрээр авч үзэхэд 2019 онд хамгийн их буюу 12.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 5.3 сая төгрөг буюу нэг хүнд дунджаар 0.004 сая төгрөг зарцуулсан нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг чанар хүртээмжтэй хэрэгжүүлж чадахгүй байх эрсдэл үүссэн байна. Харин 2020 онд уг үйлчилгээг үзүүлэхэд

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

шаардлагатай хөрөнгийг төлөвлөөгүй бөгөөд энэ нь ковид 19 цар тахлын улмаас хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх шийдвэр гарсантай холбоотой байна.

- Ажилд зуучлах үйлчилгээ: байнгын болон түр ажлын байранд 4,284 иргэнийг зуучилж 35.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 4,839 иргэнд үйлчилгээ үзүүлж 25.1 сая төгрөг зарцуулж 29.5 хувиар дутуу санхүүжүүлсэн байна. Салбарын сайдын баталсан журмаар ажил зуучлах үйлчилгээ үзүүлэхэд нэг хүнд дунджаар 0.012 сая төгрөг зарцуулахаар журамласан боловч 2016-2021 онд дунджаар нэг иргэнд 0.005 сая төгрөг зарцуулж байгаа нь зарцуулбал зохих хэмжээнээс 1 дахин бага хөрөнгө зарцуулсан тооцоо гарч байна.

2.1.3.4 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийг өмнөх онтой харьцуулан дүн шинжилгээ хийж хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг тооцож байх нь зүйтэй байна.

2.2 Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаагүй, албан ажлын байр нэмэгдээгүй, хөтөлбөрт хамрагдсан иргэд ихэвчлэн албан бус хөдөлмөр эрхэлж байна

2.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.2.1.1 Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр дараах байдалтай хэрэгжжээ.

Нэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгийн талаар:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2016-2021 онд ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах зорилгоор 634 иргэнд 2,322.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон байна. Санхүүгийн дэмжлэг олгосон байдлыг он тус бүрээр харуулбал: Хүснэгт 9

ХЭДС-ийн хөрөнгөөр ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэн, олгосон санхүүгийн дэмжлэгийн судалгаа /сая төгрөгөөр/

Хөтөлбөрийн нэр	2016		2017		2018		2019		2020		2021	
	хамрагдсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэг	хамрагдсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэг	хамрагдсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэг	хамрагдсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэг	хамрагдсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэг	хамрагдсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэг
Ажлын байр дэмжих хөтөлбөр	70	104.5	36	105.0	41	111.0	53	230.0	40	195.0	25	115.0
Залуучуудын ХЭДХ	10	20.0	7	24.0	5	27.0	15	150.0	6	60.0	1	10.0
ХБИ-ын ХЭДХ	31	35.0	13	39.0	15	40.0	11	40.0	14	55.0	19	64.0
Ахмадын ХЭДХ	-	-	4	7.5	9	12.0	12	21.0	12	24.0	12	27.0

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Малчдын ХЭДХ	16	76.0	47	225.0	48	225.0	47	215.0	-	-	15	65.0
ДҮН	127	235.5	107	400.5	118	415.0	138	656.0	72	334.0	72	281.0

Хүснэгтээс харахад 2020, 2021 онуудад хамгийн бага буюу тус бүр 72 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон үзүүлэлт харагдаж байгаа бол 2019 онд хамгийн их буюу 138 иргэнийг зээлд хамруулж 656.0 сая төгрөг зарцуулсан нь нийт олгосон санхүүгийн дэмжлэгийн 28.3 хувийг эзэлж байна.

ХЭДС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзвэл:

- 1. Ажлын байр дэмжих хөтөлбөрт:** 2016-2021 онд нийт 860.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 225 иргэнд ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах зорилгоор олгосон байна. Төсөл хөтөлбөрт хамрагдсан дээрх иргэдээс 32 хувь буюу 72 иргэн одоогоор төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж ажлын байр нэмэгдүүлээгүй байна. Төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж ажлын байр нэмэгдүүлээгүй учир шалтгааныг тодруулж үзэхэд 12 иргэн өөр аймаг, хотод шилжин суурьшсан, 1 иргэн төрийн үйлчилгээнд байнгын ажлын байранд томилогдсон бол 3 иргэн нас барсны улмаас төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй болсон бол 56 иргэн тодорхой шалтгаангүйгээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байна.
- 2. Малжуулах хөтөлбөр:** Уг хөтөлбөрт Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан шалгуур үзүүлэлтийг хангасан 13 сумын 173 залуу малчинд 806.0 сая төгрөгийн 4 төрлийн 13,507 толгой малыг олгосон байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 2021 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нийт малын тоо 38,473 толгойд хүрч 11,895 (2021 оны тооллогын дүнгээс малчдын хөтөлбөрт хамрагдахад байсан мал болон хөтөлбөрөөс олгосон малын тоог хасаж өсөлтийг тооцов.) толгой мал буюу 44.7 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна. Малын өсөлтийг малчин тус бүрээр үзэхэд 350 толгойгоос дээш мал тоолуулсан 29 иргэн байгаа бөгөөд энэ нь нийт тоолуулсан малын 35.1 хувийг эзэлж байна. Дээрх малчин иргэн нь төсөл хөтөлбөрт хамрагдахаас гадна малын тоо толгойг өсгөх зорилгоор орон нутгийн олон малтай өрхийн малыг маллаж ажлын хөлсөнд төл мал авсан нь малын тоо толгой нэмэгдэх, төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц болсон байна. Хөтөлбөрт хамрагдсан малчин иргэдээс Наран сумын малчин иргэн 806 толгой, Халзан сумын малчин иргэн 789 толгой, Онгон сумын малчин иргэн 755 толгой, Эрдэнэцагаан сумын иргэн 725 толгой, Түвшинширээ сумын иргэн 724 толгой мал тоолуулсан нь хамгийн их үзүүлэлт болж байна. Малжуулах хөтөлбөр үр дүнтэй байгаа боловч 54 иргэний мал 2021 оны жилийн эцсийн тооллогоор хөтөлбөрт хамрагдах үеийнхээс буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс 5 иргэн огт мал тоолуулаагүй бол 5 иргэн 50 хүртэл толгой мал тоолуулсан нь хөтөлбөрийн үр дүн харилцан адилгүй байгааг харуулж байна.
- 3. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:** Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төслийн хүрээнд давхардсан тоогоор 67 иргэнд 27.8 сая төгрөгийг олгосон байна. Уг төслийн хүрээнд хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж үр дүнг тооцоогүй байна. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 49 иргэнд 91.5 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон байна. Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн 81.6 хувь буюу 40 иргэн төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж байгаа бол 2 иргэн нас барж, 1 иргэн өөр аймаг суманд шилжсэн тул төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Харин 6 иргэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

4. **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:** Уг хөтөлбөрийн хүрээнд 89 иргэнд 273.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Хөтөлбөрт хамрагдсан нийт иргэдийн 36.0 хувь буюу 32 иргэн төслийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхгүй байгаа бөгөөд үүнээс 3 иргэн байнгын ажлын байранд шилжин ажиллаж байгаа бол 2 иргэн нас барж, 27 иргэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.
5. **Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:** Уг хөтөлбөрийн хүрээнд 2016-2020 онд 42 иргэнд 281.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй дэмжлэг олгосон бол 2021 онд ХЭҮЗ-ийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор баталсан Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 6 дугаар зүйлийн 6.1¹¹-т заасны дагуу 1 иргэнд эргэн төлөх нөхцөлгүй 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн олгосон байна. Төсөл хөтөлбөрт хамрагдсан залуучуудаас 50 хувь буюу 21 иргэн үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлого үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байгааг илтгэж байна.
6. **Итгэлийн зээл:** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцсэн зорилтот төслийн хүрээнд 15 иргэнд 200.0 сая төгрөгийг олгосон байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэдээс 130.0 сая төгрөгийг зээлд хамрагдсан 9 иргэн төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй, ажлын байр нэмэгдүүлээгүй байна. Одоогоор зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөөгүй 2 иргэнийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 116.4 сая төгрөг байгаа бөгөөд уг хөтөлбөр үр дүн муутай байна.
7. **Жижиг зээл:** 2017-2019 онд хэрэгжсэн бөгөөд арилжааны банкны жижиг бизнес эрхлэгчийн шалгуур үзүүлэлтийг хангасан иргэдэд олгосон бөгөөд Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн, Хаан, Голомт банкаар дамжуулан 2017 онд 350.0 сая, 2018 онд 600.0 сая, 2019 онд 283.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Зээлд хамрагдсан иргэд төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс уг хөтөлбөр ямар үр дүнтэй хэрэгжиж байгаа нь тодорхойгүй байна.

2.2.1.2 Аймгийн хэмжээнд 2016-2021 онд малжуулах хөтөлбөрөөс бусад хөтөлбөрт хамрагдсан нийт 134 иргэн буюу 29.1 хувь нь төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй бол 327 иргэн төсөл хөтөлбөрийг хэвийн /улирлын болон өдөр тутам/ явуулж байгаа дүн мэдээтэй байна. Дээрх 327 иргэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч НДШ төлдөггүй, албан бус хөдөлмөрийн эрхлэлтийн үйл ажиллагааны хэлбэртэй байна.

2.2.1.3 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хууль тогтоомжид заасны дагуу жил бүр тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталж байгаа ба ажлын байрыг дэмжих хөтөлбөрт тусгаснаар иргэдэд 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор заажээ.

2.2.1.4 Хөтөлбөрт заасны дагуу 2016-2021 онд ажлын байрыг дэмжих зорилгоор иргэнд 0.5-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Энэ нь ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хангалттай хэмжээний санхүүжилт болж чадаагүй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ,

¹¹ Аймагт аймгийн ХХҮГ,.....шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-Ап” залуу, эсхүл залуучуудын багийг шалгаруулж, 10.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгоно.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

үйлчилгээ нь нийгэмд ажилгүйдлийг бууруулах, дэмжих үндсэн үүргээ төдийлөн үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй, түр ажлын байраар амиа аргацаасан байдалтай, албан бус салбарт өргөжсөн байна.

2.2.1.5 Орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал, нийгмийн бүлгүүдийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотой юм.

2.2.1.6 Сүүлийн жилүүдийн бараа таваарын үнийн өсөлт, иргэдийн амьжиргааны түвшин, ажлын бүтээмж доогуур, цалин хөлс хангалтгүй зэргээс шалтгаалан шинээр ажлын байр нэмэгдүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсэж, уг хөтөлбөр үр дүнтэй хэрэгжихгүй байхад мөн нөлөөлжээ.

Хоёр: Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн үр дүнгийн талаар:

2.2.1.7 Тус сангийн гол зорилго нь суманд жижиг дунд үйлдвэр шинээр байгуулах, үйл ажиллагааг өргөтгөж, ажлын байр нэмэгдүүлэхээр тусгажээ. Сумд 2016-2021 онуудад давхардсан тоогоор 514 иргэнд 4,857.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Сангаас олгосон зээлийг сум тус бүрээр харуулав. Хүснэгт 10

д/д	Сумын нэр	Зээлд хамрагдсан хүний тоо	Олгосон зээлийн дүн /сая төгрөг/	Төсөл хөтөлбөр		Ажлын байр	
				хэрэгжүүлж байгаа	хэрэгжүүлэхгүй байгаа	нэмэгдвэл зохих	нэмэгдсэн
1	Асгат	22	172.7	13	9	29	18
2	Баруун-Урт	114	1,507.2	92	22	284	218
3	Баяндэлгэр	79	323.4	65	14	95	58
4	Дарьганга	26	205.0	20	6	53	37
5	Мөнххаан	35	219.6	35	2	67	52
6	Наран	28	267.0	18	9	46	31
7	Онгон	34	336.0	20	14	66	32
8	Сүхбаатар	32	254.5	22	10	36	27
9	Түвшинширээ	18	236.0	11	7	46	36
10	Түмэнцогт	28	272.7	23	5	47	37
11	Уулбаян	27	266.0	20	7	49	30
12	Халзан	45	329.7	39	6	45	36
13	Эрдэнэцагаан	26	467.2	10	16	68	18
ДҮН		514	4,857.0	388	127	931	630

2.2.1.8 Хүснэгтээс харахад нийт зээлд хамрагдсан иргэдийн 127 буюу 32.7 хувь нь төсөлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна. Харин Эрдэнэцагаан сумын СХС-ийн зээлд хамрагдсан иргэдийн 16 буюу 61.5 хувь нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхгүй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарч байна. Мөн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлснээр 931 ажлын байр нэмэгдүүлэхээр төсөлд тусгаснаас 630 ажлын байр нэмэгдсэн гэсэн дүн мэдээ гарсан байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Хэдийгээр 630 шинэ ажлын байр бий болсон гэж үзэж байгаа боловч байнгын ажлаар хангаж НДШ төлөхгүй байна.

Гурав. ЖДҮ-ийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:

2.2.1.9 Аймгийн ХХААГ-аар дамжуулан ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд шалгуур үзүүлэлт, шаардлагад нийцсэн 9 төслийг 1,000.0 сая, 2020 онд 4 төслийг 425.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн санхүүжилтийг олгосон байна. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг авч үзвэл.

- Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 4 төсөлд 553.0 сая төгрөг
- Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 5 төсөлд 276.8 сая төгрөг
- Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3 төсөлд 542.9 сая төгрөг
- Үйлчилгээний чиглэлээр 1 төсөлд 52.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2.2.1.10 Дээрх 13 төсөл хөтөлбөрийг хүрээнд ЖДҮ-ийг хөгжүүлж 53 ажлын байрыг шинээр нэмэгдүүлэхээр байгаа боловч одоогийн байдлаар 10 төслийн үйл ажиллагааг эхлүүлж 28 шинэ ажлын байр нэмэгдүүлэн ажиллаж байгаа бол 3 төслийг ковид цар тахлын улмаас хил хаагдаж шаардлагатай материал, тоног төхөөрөмжийг татаагүй гэх шалтгаанаар үйл ажиллагааг эхлүүлээгүй, үйлдвэрийн өргөтгөлийг дутуу хийсэн байна.

2.2.1.11 Төсөл хамрагдсан аж ахуйн нэгжээс Оранж бэйкери үйл ажиллагаагаа өргөжүүлж хамгийн олон буюу 12 хүнийг ажлын байраар хангаж байгаа нь төслийг үр дүнтэй хэрэгжүүлж байна гэж үзлээ.

2.2.1.12 Төсөлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж төслийг зохих хэмжээнд хэрэгжүүлж байгаа боловч ажиллаж байгаа иргэдийн НДШ-ийг төлөхгүй албан бусаар хөдөлмөр эрхлүүлж байна. Тухайлбал: Манхат баян уул ХХК 6 хүн ажиллаж байгаагийн 2, Оранж бэйкери 12 хүн ажиллаж байгаагаас 2, Бат гарьд эрдэс баяр ХХК 10 хүн ажиллаж байгаагийн 3 хүний НДШ-ийг төлж 21 хүнийг албан бусаар хөдөлмөр эрхлүүлжээ.

2.2.1.13 Мөн 4 аж ахуйн нэгж ХХААЯ-ны ЖДҮДС-аас 934.1 сая төгрөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх хөнгөлөлттэй зээлд хамрагдсан бөгөөд 3 аж ахуйн нэгж үйл ажиллагааг хэвийн явуулж байгаа бол 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа зогссон байна.

Дөрөв. Сүхбаатар хөгжил үйлдвэр технологийн паркаар дамжуулан олгосон ажлын байр нэмэгдүүлэх хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон зээлийн талаар :

2.2.1.14 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу ЖДҮ-ийг хөгжүүлэх зорилгоор 2017 онд “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ийг байгуулан ЖДҮ-ийг хөгжүүлэхээр 11 иргэн, аж ахуйн нэгжид орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 891.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

2.2.1.15 ЖДҮ-ийн хөгжүүлэх дээрх төслүүдээс 409.4 сая төгрөгийн 5 төсөл зориулалтын дагуу ажиллаж 10-15 иргэнийг байнгын болон түр ажлын байраар ханган ажиллажээ.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2.2.1.16 Харин 431.6 сая төгрөгийн 8 төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн боловч зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тооцоо судалгаа, үйлдвэрлэлийн хүчин чадал зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагаа зогсож ЖДҮ-ийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх зорилтыг хангах боломжгүй болжээ.

2.2.1.17 Хэдийгээр орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөр үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа ч хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг оновчтой тодорхойлоогүйгээс төсөл, хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж чадахгүй байна.

2.2.1.18 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан зарим иргэдтэй уулзах явцад ажлын байрыг өргөтгөх, байнгын ажлын байр нэмэгдүүлэх боломжтой юу гэсэн асуултад дараах хариултыг өгч байна. Үүнд:

- Ажлын байранд ажилтан дадлагажуулж авах зар тавихаар хүн ирдэггүй;
- Ажил хөдөлмөр хийх хүсэлгүйгээс 3-7 хоног ажиллаад гардаг;
- Зарим иргэн тухайн ажлын байранд ажиллах мэргэжил, ур чадвар дутагддаг гэсэн тайлбарыг гаргаж байна;
- Нийгмийн халамжийн хамрах хүрээг оновчлох, халамжид хамрагдалтыг аль болох бууруулах шаардлагатайг онцолж байна.

2.2.1.19 Хөдөлмөрийн насны иргэд ажил хөдөлмөр эрхлэх хүсэл зорилгогүй, боломжтой тохиолдолд халамжийн үйлчилгээнд хамрагдаж амар хялбар аргаар орлогоо нэмэгдүүлэх сонирхол давамгайлжээ.

2.2.1.20 Сүүлийн жилүүдэд аймгийн хэмжээнд халамжийн 10 хөтөлбөрийн 72 үйлчилгээнд давхардсан тоогоор 28.0-29.0 мянган иргэн тогтмол хамрагдаж байгаа ажил хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бууруулж, бэлэнчлэх сэтгэлгээг хүүхэд залуучуудад олгож байна.

2.2.1.21 Иймд иргэдийн ажил хөдөлмөр эрхлэхэд сэдэл өгөх сургалт, сурталчилгааг үе шаттайгаар хүргэх, хөтөлбөрийн үр дүнд шинжилгээ хийх, ЖДҮ, СХС-удыг нэгтгэн зохион байгуулж, аль болох том төслүүдийг дэмжих, төрийн бодлогыг оновчлох шаардлага үүссэн байна.

2.2.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй хэрэгжжээ.

2.2.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланг гаргаж Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Төрийн аудитын байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулжээ. Аудитын байгууллагаас ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгчээ.

2.2.2.2 Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг сар бүр батлагдсан маягтын дагуу гарган ХХҮЕГ-т хүргүүлж байна.

2.2.2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төсөл хөтөлбөрийн талаарх мэдээ тайланг ирүүлэх талаар зохицуулсан байна. Гэсэн хэдийн 2016-2021 онд ажлын байрыг дэмжих, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Ахмадын хөдөлмөр

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан 150 иргэн буюу нийт иргэдийн 42.3 хувь нь төслийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй байна.

2.2.2.4 ХХҮГ-ийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс нь төсөл хэрэгжүүлэгчээс тайлан мэдээг төсөл хэрэгжиж эхлэх болон гэрээний хугацаа дуусах гэсэн 2 хэлбэрээр тайлан мэдээг авч байна. Тайлант мэдээнд дүн шинжилгээ, хийх, үнэлгээ дүгнэлт өгөх зэрэг чиг үүргийг ХХҮГ-ийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод тусгасан боловч уг ажил хангалтгүй хэрэгжиж байна.

2.2.2.5 Сумын ХЭХАХМ-ний албан тушаалын тодорхойлолтод хөдөлмөр эрхлэлтийн талаар 4 зорилтын хүрээнд 17 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан ч өдөр тутмын үйл ажиллагаа халамжийн үйлчилгээнд голчлон чиглэгдэж байгаа нь ажлын ачаалал их, иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, төсөлд хөтөлбөрт хамруулах, хөдөлмөр эрхлэлтийн талаарх тайлан мэдээ гаргах чиг үүрэг хангалтгүй хэрэгжихэд нөлөөлжээ.

2.2.2.6 Аймгийн ХХҮГ-ийн дотоод хяналт, шалгалтын 2 орон тоотой бөгөөд дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд хяналт, шалгалтын төлөвлөгөө, удирдамжийг батлуулан хэрэгжүүлж байна.

2.2.2.7 Байгууллагын дотоод хяналт, шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ ихэнх тохиолдолд халамжийн үйлчилгээг голлон хэрэгжүүлжээ.

2.2.2.8 Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ зөвхөн иргэдийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд хяналт хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналт төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, мэдээллийн нэгдсэн сангийн тайлан мэдээ гаргалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх зэрэг үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.2.2.9 Дотоод хяналтын нэгжээс хөдөлмөр эрхлэлттэй холбоотой алдаа зөрчлийг арилгах, сумдын мэргэжилтэн болон удирдлагуудад арга зүйн зөвлөгөө өгөх, алдаа зөрчил давтан гаргасан албан хаагчдад хууль тогтоомжид заасан сахилгын хариуцлага тооцуулах зэрэг үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай юм.

2.2.2.10 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2016 оны 153¹² дугаар тогтоолоор баталсан журмын /2022 оны 81 тогтоолоор хүчингүй болсон/ 5.3.1¹³-т заасны дагуу зээл авсан иргэнээр гаргуулан авахаар зохицуулсан боловч төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг зээлэгдэгч нар ирүүлээгүй байна.

2.2.2.11 Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг тухайн сумын ИТХ-ийн шийдвэрээр томилогдсон зөвлөл хэрэгжүүлж байгаа боловч үйл ажиллагаанд тогтмол хяналтыг хэрэгжүүлдэггүй, хяналт шалгалт хийсэн тайлан

¹² Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам

¹³ зээл авсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулан авах;

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

мэдээг ИТХ-аар хэлэлцүүлэх байгаа нь Засгийн газрын 2016 оны 153¹⁴ дугаар тогтоолоор баталсан журмын /2022 оны 81 тогтоолоор хүчингүй болсон/ 5.3.2¹⁵-т заасныг зөрчиж байна. Мөн уг журмын 5.3.3¹⁶-т аймгийн ЗДТГ-аас жил тутамд сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүн мэдээг аймгийн ИТХ, жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр журамласан боловч дээрх хяналт шалгалтын ажил хэрэгжихгүй байна.

2.2.2.12 Сүхбаатар сум БЭМС-ийн хөрөнгөөр цөөн малтай иргэдийг малжуулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлжээ.

2.2.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлж, дүгнээгүй байна

2.2.3.1 Аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Жендерийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, нөлөөллийн ажлын нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээг тусгасан боловч хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар тусгайлан зорилт арга хэмжээг тусгаагүй байна.

2.2.3.2 Аймгийн ИТХ-ын 2019 оны 10/07 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн хөгжлийн зорилт 2020-2028” хөгжлийн бодлогын баримт бичгийн 4.4 эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн тэгш байдлыг хангах зорилтыг дэвшүүлж уг зорилтыг хангахын тулд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Одоогийн тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаагүй байгаа тул зорилт арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна.

2.2.3.3 Аймгийн ХЭДС-ийн хөрөнгөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор олгосон санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн 113 буюу 50.9 хувийг эмэгтэйчүүд эзэлжээ.

2.2.3.4 Мөн 2016-2021 онд ажил хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүн амын дунджаар 47.3 буюу 12,841 эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд хөдөлмөрийн насны нийт эмэгтэйчүүдийн 62.3 хувь нь ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн тооцоо судалгаа гарсан байна.

2.2.3.5 Жендерийн тэгш байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.10¹⁷-д аж ахуйн нэгж байгууллага нь хүйсийн тэнцвэртэй байдлын тухай тайлангаа сумын ЗДТГ-т ирүүлэхээр хуульчилсан боловч Жендерийн үндэсний хорооноос зөвхөн сумын ЗДТГ-ын ажилчдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг авчээ.

2.2.3.6 Хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагаас хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг авахгүй байгаа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын

¹⁴ Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам

¹⁵ сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;

¹⁶ аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжийн хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлэх.

¹⁷ аж ахуйн нэгж, байгууллага нь хүйсийн тэнцвэртэй байдлын тухай тайлангаа жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

байраар хангах, жендерийн тэгш байдлыг хангах байдал алдагдах эрсдэл үүсэж байгаад анхаарал хандуулах нь зүйтэй байна.

2.3 ХЭДС-ин хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулж байгаа боловч ХБИ ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагын төлбөрийг бүрэн төлөөгүй байна.

2.3.1 ХЭДС-д зөвхөн улсын төсвөөс санхүүжилт олгосон байна

2.3.1.1 Аймгийн ХЭДС-д улсын төсвөөс санхүүжилтийг олгож байгаа бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журмын 2.3¹⁸-д орон нутгийн төсвөөс тус санд санхүүжилт олгохоор заасан боловч 2016-2021 онд санхүүжилт олгоогүй байна. ХЭДС-д улсын төсвөөс олгосон санхүүжилтийг он тус бүрээр харуулав. График 4



2.3.1.2 Аймгийн ХЭДС-д Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7¹⁹, 22.1.8²⁰-т заасан орлогыг төвлөрүүлж дээд шатны төсөв захирагчийн дансанд төвлөрүүлж байна. Үүнд

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг Засгийн газрын 2009 оны 26, 2019 оны 111 дүгээр тогтоолоор баталсан хэмжээгээр ногдуулж байгаа бөгөөд 2016-2017 онд 17 байгууллагаас 189.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

ХХҮЕГ-ийн тушаалаар баталсан төсвийн хуваарь Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг 2020, 2021 онд тус бүр 10.0 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан. Дээрх орлогыг он тус бүрээр авч үзвэл:

- 2016 онд 4 байгууллагаас 9 иргэний 6.4 сая;
- 2017 онд 5 байгууллагын 26 иргэний 17.9 сая;
- 2018 онд 3 байгууллагын 11 иргэний 9.2 сая;
- 2019 онд 4 байгууллагаас 14 иргэний 29.5 сая;
- 2020 онд 5 байгууллагаас 12 иргэний 44.5 сая;
- 2021 онд 6 байгууллагын 12 иргэний 81.3 сая төгрөгийг тус тус төлсөн байна.

¹⁸ Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэд санд төвлөрүүлнэ.

¹⁹ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;

²⁰ ижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө;

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Төрийн болон хувийн хэвшлийн 32 байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр 123.2 сая төгрөгийг төлөөгүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3²¹-т заасныг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

2. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 2016-2021 онд нийт 1,615.8 сая төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна. Санхүүгийн дэмжлэгээс эргэн төлөгдсөн хөрөнгийг он тус бүрээр харуулав.График 5



Графикаас харахад санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 2021 онд 560.6 сая төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлсэн харагдаж байна. Энэ тус сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, дэмжлэгийн эргэн төлөлтийг хуваарийн

дагуу төлж барагдуулаагүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, санхүүгийн дэмжлэгийг барагдуулах албан шаардлагыг Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн байна. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс гэрээний хугацаа дууссан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлээгүй зэрэг 29 иргэнийг шүүхэд шилжүүлсэн нь эргэн төлөлтийг төлүүлэхэд бодит түлхэц болсон байна.

2.3.2 ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулжээ.

2.3.2.1 Аймгийн ХЭДС-ийн хөтөлбөр арга хэмжээнд 2017-2021 онд 3,929.6 сая төгрөгийн санхүүжилт олгож 3,780.6 сая төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 149.0 сая төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна. ХЭДС-ийн орлого зарлагыг он тус бүрээр харуулав.Хүснэгт 11

Он	/сая төгрөгөөр/		
	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэлээр гарсан зардал	зөрүү
2016	388.0	388.0	0.0
2017	635.1	611.0	24.1
2018	713.5	650.6	62.9
2019	1,124.0	1,121.0	3.0
2020	486.7	473.6	13.1
2021	582.2	536.3	45.9
ДҮН	3,929.6	3,780.6	149.0

2.3.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу захиран зарцуулсан байна. Үүнд:

²¹ Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

- Гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 38.5 хувь буюу 1,458.5 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт, 21.3 хувь буюу 806.0 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт тус тус олгосон байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.10²²-т заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа болох сургалт сурталчилгаа, гарын авлага хэвлэмэл материал бэлтгэх, хяналт шалгалт хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 234.6 сая төгрөг;
- Мөн ажилгүй иргэнийг түр хугацаагаар ажиллуулах, орлого нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийтийн хамарсан ажил зохион байгуулахад 375.8 сая төгрөг;
- Харин 905.7 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1²³-т заасан ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд захиран зарцуулсан байна.

2.4 МСҮТ-ийн төгсөгчид мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхлэлт хангалтгүй, хөдөлмөрийн зах зээлд шингээлт багатай мэргэжлээр элсэлт авах эрсдэл үүссэн байна.

2.4.1 Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 39.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулжээ.

2.4.1.1 Сүхбаатар аймаг дахь МСҮТ-ийн 2016-2021 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг улсын төсвөөс 6,163.0 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 66.0 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,160.5 сая төгрөгийн урсгал санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 40.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Тус МСҮТ-ийн төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийг он тус бүрээр харуулав. Хүснэгт 12

Он	Санхүүжилт /сая төгрөгөөр/				Зөрүү	
	Төлөвлөгөө		Гүйцэтгэл			
	Төсөв	Өөрийн орлогоос	Төсөв	Өөрийн орлогоос	Төсөв	Өөрийн орлогоос
2016	949.5	11.0	949.5	5.2	0.0	5.8
2017	921.0	11.0	918.5	10.8	2.5	0.2
2018	901.0	11.0	901.0	11.3	0.0	-0.3
2019	1,061.6	11.0	1,061.6	7.1	0.0	3.9
2020	1,182.2	11.0	1,182.2	3.6	0.0	7.4
2021	1,147.7	11.0	1,147.7	2.0	0.0	9.0
ДҮН	6,163.0	66.0	6,160.5	40.0	2.5	26.0

²² хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг хянах, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, сурталчилгаа явуулах, гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх хэвлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх;

²³ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна:

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2.4.1.2 Хүснэгтээс харахад урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг бүрэн санхүүжүүлсэн байгаа бол үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлого 26.0 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн харагдаж байна. Өөрийн орлого хэдийгээр тасарсан харагдаж байгаа боловч зарим онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж захиран зарцуулсан байна. Тухайлбал: үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 2016 онд 9.8 сая, 2018 онд 10.6 сая, 2019 онд 8.2 сая, 2020 онд 2.5 сая, 2021 онд 8.5 сая нийт 39.6 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж захиран зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1²⁴ –т заалтыг зөрчиж байна.

2.4.1.3 Сүхбаатар МСҮТ нь 2016-2021 онд нийт 6,243.0 сая төгрөгийг иргэнд мэргэжлийн боловсрол олгох, ажиллах хүч бэлтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна. хөрөнгийн зарцуулалтыг он тус бүрээр харуулав. Хүснэгт 13

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	455.4	448.1	464.8	584.8	673.6	724.0
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50.3	50.8	56.1	71.5	83.0	93.3
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол	245.2	193.6	190.7	194.1	186.8	188.7
4	Хангамж, бараа материалын зардал	13.7	13.9	15.6	14.2	21.9	19.2
5	Нормативт зардал	67.5	61.5	54.6	43.1	23.9	24.9
6	Эд хогшил, урсгал засварын зардал	10.8	36.4	19.6	15.0	9.3	25.1
7	Томилолт, зочны зардал	3.9	5.0	4.9	5.0	0.1	-
8	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4.7	4.7	5.5	5.5	3.8	6.7
9	Бараа үйлчилгээний бусад зардал	42.5	47.0	49.5	44.9	34.4	27.6
10	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79.8	85.1	54.2	86.5	150.6	46.1
	ДҮН	973.8	946.1	915.5	1,064.6	1,187.4	1,155.6

2.4.1.4 МСҮТ-ийн төсвийн зарцуулалтад жил тутам Төсвийн тухай хууль заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд аудитаар илэрсэн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоох, албан шаардлага хүргүүлэх болон санхүүгийн захиран зарцуулалтыг сайжруулах зөвлөмжийг өгөх зэрэг захиргааны шийдвэрийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.

2.4.2 МСҮТ-ийн төгсөгчдийн 30.8 хувь нь мэргэжлийн дагуу ажлын байраар хангагджээ.

2.4.2.1 Сүхбаатар аймаг дахь МСҮТ-д Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс санхүүжилт олгож байна.

²⁴ .хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2.4.2.2 Дээрх чиг үүргийн хүрээнд 2016-2021 онд 16 мэргэжилд шинээр 1,125 суралцагчийг элсүүлж мэргэжлийн боловсролын 1-2.5 жилийн ангид суралцуулж 1,041 иргэнд эзэмшүүлж төгсгөсөн байна.

2.4.2.3 Сүхбаатар аймаг дахь МСҮТ-ийн 2016-2020 онд төгссөн иргэдийн мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхэлж байгаа байдлыг МСҮТ-ийн гаргасан статистик мэдээнээс үзэхэд нийт төгсөгчдийн 30.8 хувь буюу 321 суралцагч ажил мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхэлж байна.

Мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхэлж байгаа байдлыг мэргэжил тус бүрээр харуулав. Хүснэгт 14

№	Олгосон мэргэжил	Төгсөгчийн тоо	мэргэжлийн дагуу ажиллаж байгаа	
			хүний тоо	хувь
1	Тогооч	106	42	39.6
2	Авто машины засварчин	49	22	44.9
3	Гагнуурчин	83	22	26.5
4	Модон эдлэлийн мужаан	44	15	34.1
5	Барилгын өрөг угсрагч	83	21	25.3
6	Барилгын засал чимэглэлч	208	77	37.0
7	Барилгын сантехникч	44	11	25.0
8	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	151	44	29.1
9	Барилгын цахилгаанчин	53	14	26.4
10	Гоо засалч	66	23	34.8
11	Цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан	22	6	27.3
12	Ардын бүжгийн бүжигчин	6	-	0.0
13	Үндэсний найрал хөгжмийн хөгжимчин	11	-	0.0
14	Фермерийн аж ахуй эрхлэгч /МАА-ГТ/	49	15	30.6
15	Төмөр замын замчин	40	-	0.0
16	Бетон арматорчин	26	9	34.6
ДҮН		1041	321	30.8

2.4.2.4 Орон нутагт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил эрчимтэй хийгдэж байгаагаас барилгын өрөг угсрагч, засал чимэглэл, сантехник, цахилгаанчин, гагнуурчин гэх мэт ангийг төгссөн сурагчид мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхлэх байдал түлхүү ажиглагдаж байна. Тухайлбал эзэмшсэн мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийн 47.9 хувь буюу 154 төгсөгч барилгын өрөг, засал чимэглэл, сантехник, цахилгаанчин зэрэг ажил хөдөлмөр эрхэлж байна.

2.4.2.5 Барилгын өрөг, засал чимэглэл, сантехник, цахилгаанчин, тогооч зэрэг ажил мэргэжил нь аймгийн хэмжээнд гаргасан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаагаар илүүдэл үүсэх тооцоо судалгаа гарч байгаа тул цаашид дээрх мэргэжлээр дахин мэргэжилтэн бэлтгэн гаргах эсэх талаар тооцоо судалгаа хийж, анхаарч ажиллах нь зүйтэй байн

2.4.2.6 Харин ардын бүжигчин, үндэсний найрал хөгжимчин, төмөр замын замчин гэсэн мэргэжлээр 57 мэргэжилтэн бэлтгэн төгсгөсөн боловч уг ажил мэргэжлийн

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

дагуу ажлын байраар хангагдаагүй байна. Энэ нь бүс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд үндэслэн хэрэгцээ шаардлагатай ажил, мэргэжлээр сурагчдыг бэлтгэхгүй байна гэж үзлээ.


2.4.2.7 Мөн сургалтын хөтөлбөр, дадлагын ажил, багшийн заах арга зүй, мэдлэг ур чадварыг сайжруулах, мэргэжлээрээ ажиллах хөдөлмөр эрхлэлт хангалтгүй байгаад дүгнэлт хийх, боловсролын салбарын бодлогыг илүү хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах шаардлагатай байна.

2.4.2.8 МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох, төрөөс үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх замаар дунд болон урт хугацаанд оршин тогтнох боломжгүйг дээрх үр дүн илтгэж байгаа бөгөөд санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, илүү үр дүнд суурилсан чадамж суулгах хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх нь зүйтэй.

2.5 Төрөөс цар тахлын үед иргэн аж ахуйн нэгжийг дэмжихээр татварын болон НДШ-ээс чөлөөлөх, арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох, залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл хөтөлбөр боловсруулах зэрэг арга хэмжээг авч ажиллажээ.

2.5.1 Иргэн, аж ахуйн нэгжийн ажлын байрыг хадгалах зорилгоор төрөөс арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгожээ.

2.5.1.1 Монгол улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөний дагуу ажлын байрыг дэмжих зорилгоор Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкаар дамжуулан 258 иргэнд 14,921.7 сая, 75 аж ахуйн нэгжид 13,465.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгосон байна. Хөнгөлөлттэй нөхцөлтэй олгосон зээлийг арилжааны банк тус бүрээр харуулбал: График 5



2.5.1.2 Ажлын байрыг хадгалах, сэргээх зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн аж ахуйн нэгжид тухайн арилжааны банкны дотоод аудит болон Монгол банкны салбараас хяналт шалгалтыг хэрэгжүүлж зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн гэрээг цуцалж, эргүүлэн татсан байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2.5.1.3 Иймд Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөний дагуу ажлын байрыг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна.

2.5.2 УИХ-аас гаргасан тогтоолын дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийг татварын болон НДШ-ийн чөлөөлөлтөд хамруулжээ.

2.5.2.1 УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр дараах багц арга хэмжээний тухай” баталсан байна.

2.5.2.2 Уг тогтоолд иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, гадаад хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчээс бусад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох ХХОАТ-аас чөлөөлөхөөр заасан байна.

2.5.2.3 Аймгийн хэмжээнд 1,310 төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаад үүнээс 1,066 байгууллага ХХОАТ чөлөөлөлтөд хамрагдсан байна.

2.5.2.4 Мөн тогтоолд ажлын байрыг хадгалах зорилгоор даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцохоор тусгасан байна.

2.5.2.5 Аймгийн НДХ-аас авсан мэдээллээр дээрх чөлөөлөлтөд 426 ажил олгогчид 3,266.8 сая төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлсэн байна.

2.5.3 Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийн хүрээнд 91 залууг хамруулж 89.0 сая төгрөгийн тэтгэлэг олгожээ

2.5.3.1 Монгол улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөөний хавсралтын 2.5-т заасныд дагуу 288 малчин иргэнд 3,484.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.

2.5.3.2 Засгийн газраас дээрх цогц төлөвлөгөөний 2.6²⁵-т заасан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2021 оны 58 дугаар тогтоолоор “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” бодлогын баримт бичгийг боловсруулсан байна.

2.5.3.3 Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийн хүрээнд 2021 онд 13 сумаас сонгогдсон 93 залуучууд бүртгэгдэж, багц сургалтад 91 залуу хамрагдсан бол

²⁵ Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

бодлогын баримт бичгийн 6.4²⁶-т заасан дадлагажуулах сургалтад 87 залууг хамруулсан байна.

2.5.3.4 Хэдийгээр төсөлд хамрагдсан залуучуудын 60.9 хувь буюу 53 нь ямар нэг ажил хөдөлмөр эрхэж байгаа гэх боловч төсөл хариуцсан мэргэжилтэн тандалт судалгааг хийгээгүйгээс одоогоор хэдэн иргэн ажил хөдөлмөр эрхэж байгаа нь тодорхойгүй байна.

2.5.3.5 Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийн 6.1²⁷-т төсөлд хамрагдаж багц сургалтад хамруулж хүн тус бүрд 1.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор тусгасан бөгөөд төсөлд хамрагдсан иргэдэд 89.0 сая төгрөгийн тэтгэлгийг Засгийн газраас олгосон байна.

2.5.3.6 Уг хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүрийн IV улиралд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр бодлогын баримт бичигт тусгасан боловч 2021 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

2.5.4 Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, мэдээ гаргаж тайлагнаагүй байна.

2.5.4.1 Аймгийн хэмжээнд цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг гаргаж нэгтгээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- 1. Бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангаж төлөвлөлт хийгдээгүйгээс орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хөрөнгө батлагдаагүй байна*
- 2. Нийгмийн халамжийн хамрах хүрээг оновчтой болгох, халамжид хамрагчдыг аль болох бууруулах шаардлагатай байна.*
- 3. Хөдөлмөр эрхлэлт, МСҮТ болон боловсролын салбарын бодлогыг уялдуулах нь зүйтэй байна.*
- 4. ЖДҮДС, СХС болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг нэгтгэх, зохицуулалтыг эрх зүйн орчинд өөрчлөх шаардлага үүссэн байна.*
- 5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ нь нийгэмд ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх үндсэн үүргээ төдийлөн үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй байна.*
- 6. ХЭДС-ийн зорилтот хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийдэггүй, ихэнхдээ түр ажлын байр, албан бус хөдөлмөр эрхлэлтэд чиглэгдсэн хэлбэртэй байна.*

²⁶ Төсөлд хамрагдаж байгаа залуучуудыг боловсролын түвшин болон хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөөнд үндэслэн ажлын байранд дадлагажуулах сургалтад хамруулна.

²⁷ Энэ төслийн 5 дахь хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулалт болон эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн залуучуудыг 1.0 (нэг) сая төгрөгийн тэтгэлэгтэй, вакумжуулсан багц сургалтад 1 сарын хугацаатай гэрээний дагуу хамруулна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

7. *Ажлын бүтээмж, гүйцэтгэлд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.*
8. *Орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал учир нийгмийн бүлгүүдийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг дэмжих шаардлагатай байна*
9. *Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулаагүй, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, орон нутагт бодлого үр дүнтэй хэрэгжээгүй байна.*
10. *Мэдээллийн нэгдсэн системд хөдөлмөр эрхлэлт, ажил зуучлах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгож үйлчилгээг давхардуулан бүртгэж, статистик мэдээ тайланг буруу гаргасан байна.*

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Шат шатны Засаг даргад

1. Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр дэд хөтөлбөр боловсруулан, шаардлагатай хөрөнгө эх үүсвэр, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг ИТХ-аар батлуулан, хэрэгжилтийг хангах
2. Салбар хоорондын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг тайлагнах;
3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаанд үндэслэн хомсдол үүсэх эрсдэлтэй ажил мэргэжлээр иргэдийг сургах, дадлагажуулах богино хугацааны бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
4. Албан бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн байнгын ажлын байраар хангах, НДШ-ийг төлүүлэх талаар төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлд

1. Зөвлөлийн үйл ажиллагааг дүрэмд заасны дагуу Аймгийн засаг дарга өөрөө удирдаж, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах;

ХХҮГ-ын даргад

1. Сумын ХЭХАХМ-ыг ажлын байрны болон чадавхжуулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлогыг иргэдэд үр дүнтэй, хүртээмжтэй хүргэх;

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2. Дотоод хяналтын ажилтныг чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл байдлаар хангах, дотоод хяналт шалгалтын тайланг хэлэлцэж үнэлгээ, дүгнэлт өгөх;
3. ХЭДС-ийн зорилтот хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж, үр дүнг сайжруулах, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлэх ажлуудыг зохион байгуулах;
4. Орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн бүлгүүдийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг дэмжих;

ХХҮГ-ын ХЭХ-ийн дарга, мэргэжилтэнд

1. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхээр олгосон санхүүгийн дэмжлэгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, үр дүнтэй хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг иргэдэд сурталчлах;
2. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн хэрэгжилтийн тайланг тогтмол авч дүн шинжилгээ хийж, төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй иргэдийн гэрээг цуцлах;
3. LMIS мэдээллийн нэгдсэн системд оруулах мэдээлэл болон батлагдсан маягтын дагуу гаргаж байгаа мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, хяналт тавих;

Сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд

1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгосон иргэдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системд давхардуулан бүртгэхгүй байх;
2. Ажилд зуучлагдсан иргэдийг үнэн зөв бүртгэж, хөдөлмөр эрхлэлтийн мэдээ тайланг үнэн зөв гаргах;

ХХҮГ-ын Дотоод хяналтын мэргэжилтэнд

1. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, мэдээ тайланг үнэн зөв гарсан эсэх зэрэг цогц төлөвлөгөө удирдамж боловсруулан хэрэгжүүлэх;
2. Хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, зөвлөмжийг албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг давтан шалгах;
3. Алдаа, зөрчлийг давтан гаргасан, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй албан хаагчид хуульд заасан хариуцлага тооцуулах саналыг удирдлагад хүргүүлж, сахилга хариуцлагыг сайжруулах;

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Холбогдох байгууллагын санал:

**СҮХБААТАР АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**


22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518032, 70518414

2022.05.05 № 1169
танай _____-ны № _____-т

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүн сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Ямар нэг санал байхгүй, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



100000302

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

**СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЭЛТЭС**


22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс.

2022.05.05 № 9/441
танай _____-ны № _____-т

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн чиглэлээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын хүрээнд дэвшүүлсэн дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд холбогдох санал байхгүй болохыг үүгээр илэрхийлж байна.



2222150232

ТАЙЛАНГ

ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.НАРАНТУЯА

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ДАВАА

БИЧСЭН: АХЛАХ АУДИТОР С.АРИУНБАЯР
АУДИТОР Б.АРИУНЗУЛ
АУДИТОР А.МӨНХЦЭЦЭГ